

Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны
гарын авлагын 2 дугаар хавсралт



БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ББМТ) ISO
21001:2018

ҮЛ ТОХИРОЛ БҮХИЙ ГАРАЛТЫН ЖУРАМ

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/PRO/005
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-05-20

НЭГ.ЗОРИЛГО

Энэхүү журам нь МУИС-ийн үйл ажиллагааны аль ч шатанд тодорхой стандартын шаардлагад нийцэхгүй аливаа үл тохирлыг олж тогтоох, тусгаарлах болон залруулах, сэргийлэх буюу зорилготой.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журмыг МУИС-ийн үйл ажиллагаа, үйлчилгээний гүйцэтгэлийн бүх үе шатанд тогтоосон шаардлагууд хамаарна.

ГУРАВ.ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бүх нэгжийн удирдлага үл тохирол гаралтын талаарх авах арга хэмжээг хариуцна.

ДӨРӨВ.ЖУРАМ

4.1. Дараах байдлаар үл тохирлыг тодорхойлон судалж, залруулга хийх тайланд бүртгэж, боломжтой бол залруулах, цаашид адил төстэй асуудал гарахаас зайлсхийхийн тулд арга хэмжээ авна. Үүнд:

- 4.1.1. Үйлчлүүлэгч болон оролцогч талуудаас ирүүлсэн санал гомдол
- 4.1.2. Хөндлөнгийн болон дотоод аудитын үр дүн, хяналтаар илэрсэн зөрчил, дутагдал
- 4.1.3. 4.1.3. Төлөвлөөгүй өөрчлөлтийн нөлөө
- 4.1.4. Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын үл нийцэл

4.2. Үл тохирлыг залруулахдаа дараах арга хэмжээнээс тохиромжтой хэлбэрийг сонгон ашиглана. Үүнд:

- 4.2.1. Залруулах арга хэмжээ;
- 4.2.2. Үл тохирлыг тусгаарлах, битүүмжлэх, буцаах буюу болиулах;
- 4.2.3. Сонирхогч талуудад энэ тухай мэдээлэх;
- 4.2.4. Тохиролцсоны үндсэн дээр зөвшөөрүүлэх.

4.3. МУИС-ийн сургуулийн өдөр тутмын дотоод гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг залруулах боломжийг нэгжийн удирдлагын түвшинд үнэлж сайжруулна.

4.4. Урт хугацааны өгөгдөл, чиг хандлагын шинжилгээ, сайжруулах боломжийг удирдлагын дүн шинжилгээний түвшинд үнэлж сайжруулна.

4.5. Бүх үл тохирлын гаралтын шалтгааныг судлах, хэрхэн залруулах, залруулах арга хэмжээний дүнг тооцох асуудлыг залруулах арга хэмжээний журмаар зохицуулна.

ТАВ.ЛАВЛАГААНЫ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

- 5.1. Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- 5.2. Судалгааны ажлын ёс зүйн журам
- 5.3. Залруулах арга хэмжээний журам.
- 5.4. Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээний журам

ЗУРГАА.БҮРТГЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

Залруулах арга хэмжээний тайлан

ДОЛОО.ХЯНАЛТЫН ТҮҮХ

Хяналтын №	Өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл	Хяналтын огноо	Өөрчлөлтийн шалтгаан	Хийгдсэн өөрчлөлт	Өөрчлөлтүүдийг зөвшөөрсөн
00	Анхны хувилбар	DD.MM.YY	--	--	--